

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2025/137/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Аудитын менежер М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: <a href="mailto:altantuuya@audit.gov.mn">altantuuya@audit.gov.mn</a> Ахлах аудитор Н.Батчимэг Утас 91113253 Цахим хаяг : <a href="mailto:batchimegn@audit.gov.mn">batchimegn@audit.gov.mn</a> Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Баян ташаагийн эх” аудит ХХК Захирал Т.Хоролсүрэн Утас: 99116028 Цахим хаяг: <a href="mailto:bte.audit@yahoo.com">bte.audit@yahoo.com</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явах хэрэгсэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

**БАЯНХОНГОР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН ЭРДЭМ  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ц.ЗАГДСҮМ ТАНАА**

2025.01.25 № 2/24  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2024 онд 3,774,679,5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 3,520,397,3 мянган төгрөгийг зарцуулж, 97,6 төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 252,852,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны

**5020361**

гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95 хувьтай тайлагнасныг 93,3 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>386,022,640.24</b>	<b>477,307,344.50</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	235,701,857.63	252,852,884.69
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	235,701,857.63	252,852,884.69
31211	Төрийн сангийн харилцах	235,701,857.63	252,852,884.69
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		
<b>335</b>	<b>Бусад авлага</b>		350,000.00
3351	Байгууллагаас авах авлага		350,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		350,000.00
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	150,320,782.61	224,104,459.81
35110	Тусгай зориулалттай материал	91,614,765.11	89,293,674.31
35130	Эм боох материал	88,046,525.11	89,293,674.31
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	3,568,240.00	
35410	Бичиг хэргийн материал	58,706,017.50	134,810,785.50
35420	Аж ахуйн материал	635,000.00	840,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,025,809.00	2,005,809.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,560,171,971.65</b>	<b>2,607,762,936.43</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,560,171,971.65	2,607,762,936.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,186,506,971.57	2,235,000,436.31
39202	Хуримтлагдсан элэгдэл	2,085,043,408.24	2,085,043,408.24
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	-232,752,926.56	-280,337,533.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	444,512,994.54	647,292,641.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-182,107,802.07	-291,601,223.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	134,274,601.83	154,286,575.23
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-76,483,031.86	-88,290,494.01
39214	Бусад үндсэн хөрөнгө	194,732.56	194,732.56
39215	Хуримтлагдсан элэгдэл	38,636,471.60	38,636,471.60
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-24,811,476.71	-30,224,141.99
39301	Програм хангамж	373,665,000.08	372,762,500.12
39302	Хуримтлагдсан элэгдэл	8,939,860.00	8,939,860.00
39303	Бусад биет бус хөрөнгө	-3,524,859.92	-4,427,359.88
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>368,250,000.00</b>	<b>368,250,000.00</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,946,194,611.89</b>	<b>3,085,070,280.93</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>52,945,223.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>		52,945,223.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		52,945,223.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>		1,204,475.00
41361	Байгууллагад төлөх өглөг		<b>51,740,748.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,946,194,611.89</b>	<b>3,032,125,057.93</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,946,194,611.89	3,032,125,057.93
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,627,034,865.06	1,627,034,865.06
51210	Өмнөх үеийн үр дүн	<b>465,757,051.26</b>	<b>551,687,497.30</b>
51220	Тайлант үеийн үр дүн	465,757,051.26	465,757,051.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		85,930,446.04
		853,402,695.57	853,402,695.57

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,946,194,611.89	3,085,070,280.93
---	--	------------------	------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,137,910,400.00</b>	<b>3,690,169,387.60</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,194,000.00</b>	<b>168,269,787.60</b>
120	Нийтлэг татварын бус орлого	5,194,000.00	168,269,787.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,194,000.00	124,608,019.60
120042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,194,000.00	15,746,350.00
120045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		3,280,049.20
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,132,716,400.00</b>	<b>3,521,899,600.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	984,551,600.00	3,206,983,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	984,551,600.00	3,206,983,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	148,164,800.00	314,915,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	148,164,800.00	314,915,700.00
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,314,696,813.06</b>	<b>3,604,238,941.56</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,314,696,813.06</b>	<b>3,604,238,941.56</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,256,135,313.06</b>	<b>3,490,402,538.44</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	906,518,071.32	2,479,306,941.91
210101	Үндсэн цалин	665,382,180.12	1,446,615,904.96
210102	Нэмэгдэл	216,493,189.13	736,167,800.50
210104	Урамшуулал	24,642,702.07	296,523,236.45
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>97,434,033.29</b>	<b>289,029,021.28</b>
210201	Тэтгэврийн даатгал	66,673,331.62	192,013,097.48
210202	Тэтгэмжийн даатгал	7,837,143.42	25,350,501.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,243,314.60	12,672,925.79
210204	Ажилгүйдлийн даатгал	1,516,385.70	12,678,350.88
210205	Эрүүл мэндийн даатгал	15,163,857.95	46,314,145.90
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>144,810,141.51</b>	<b>307,326,896.88</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,648,793.51	13,912,066.88
210302	Түлш, халаалт	124,362,900.00	264,915,248.00
210303	Цэвэр, бохир ус	14,798,448.00	28,499,582.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,831,765.79</b>	<b>51,776,264.57</b>
210401	Бичиг хэрэг	7,761,970.00	32,897,392.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	441,445.79	6,282,522.57
210404	Ном, хэвлэл		2,032,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	600,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	4,328,350.00	9,963,450.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>139,630.00</b>	<b>59,497,613.00</b>
	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	139,630.00	4,209,040.00
210502	Хоол, хүнс		55,288,573.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,488,400.00</b>	<b>25,675,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		8,287,000.00



**Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210604	Урсгал засвар	2,488,400.00	17,388,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,325,000.00</b>	<b>34,966,278.18</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,325,000.00	34,966,278.18
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>86,588,271.15</b>	<b>242,823,822.62</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,685,000.00	67,623,167.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,157,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,746,271.15	175,200,655.62
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>58,561,500.00</b>	<b>113,836,403.12</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>58,561,500.00</b>	<b>113,738,800.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,561,500.00	69,811,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		43,927,300.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>		<b>97,603.12</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		97,603.12
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-176,786,413.06</b>	<b>85,930,446.04</b>
	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>-176,786,413.06</b>	<b>85,930,446.04</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,698,283,200.00</b>	<b>3,537,645,950.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,944,000.00</b>	<b>15,746,350.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>8,944,000.00</b>	<b>15,746,350.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>5,194,000.00</b>	<b>15,746,350.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,194,000.00	15,746,350.00
120009	Бусад орлого	3,750,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,689,339,200.00</b>	<b>3,521,899,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,513,455,800.00</b>	<b>3,206,983,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,513,455,800.00	3,206,983,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>175,883,400.00</b>	<b>314,915,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	175,883,400.00	314,915,700.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,591,510,830.49</b>	<b>3,455,025,670.94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,591,510,830.49</b>	<b>3,455,025,670.94</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,514,451,330.49</b>	<b>3,285,900,694.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,173,405,337.96</b>	<b>2,478,102,466.91</b>
210101	Үндсэн цалин	869,962,212.91	1,445,411,429.96
210102	Нэмэгдэл	275,361,312.98	736,167,800.50
210104	Урамшуулал	28,081,812.07	296,523,236.45
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>145,802,873.22</b>	<b>289,379,021.28</b>
210201	Тэтгэврийн даатгал	99,747,014.09	192,013,098.08
210202	Тэтгэмжийн даатгал	11,557,639.43	25,350,501.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,397,647.72	12,672,925.79
210204	Ажилгүйдлийн даатгал	2,281,867.93	12,678,350.88
210205	Эрүүл мэндийн даатгал	22,818,704.05	46,664,145.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>152,622,023.52</b>	<b>307,326,896.88</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,557,451.52	13,912,066.88
210302	Тулш, халаалт	124,362,900.00	264,915,248.00
210303	Цэвэр, бохир ус	20,701,672.00	28,499,582.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,391,000.00</b>	<b>7,491,200.00</b>



**Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210604	Урсгал засвар	1,391,000.00	7,491,200.00
210701	Томилолт, зочны зардал	720,400.00	
210702	Дотоод албан томилолт	720,400.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,445,000.00</b>	<b>49,239,078.18</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,445,000.00	49,239,078.18
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,064,695.79</b>	<b>154,362,031.57</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,053,825.79	132,894,639.57
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,010,870.00	21,467,392.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		43,927,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>77,059,500.00</b>	<b>169,124,976.12</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>77,059,500.00</b>	<b>169,124,976.12</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	77,059,500.00	169,124,976.12
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		97,603.12
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>106,772,369.51</b>	<b>82,620,279.06</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>4,415,000.00</b>	<b>65,469,252.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,415,000.00</b>	<b>65,469,252.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,415,000.00</b>	<b>65,469,252.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,415,000.00	65,469,252.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-4,415,000.00</b>	<b>-65,469,252.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>102,357,369.51</b>	<b>17,151,027.06</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	217,359,952.21	235,701,857.63
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	319,717,321.72	252,852,884.69

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,627,034,865.06	853,402,695.57	464,562,172.26	2,944,999,732.89
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
9	Тайлант үеийн үр дүн			1,194,879.00	1,194,879.00
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,627,034,865.06	853,402,695.57	465,757,051.26	2,946,194,611.89
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,627,034,865.06	853,402,695.57	465,757,051.26	2,946,194,611.89
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
19	Тайлант үеийн үр дүн			85,930,446.04	85,930,446.04
20	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,627,034,865.06	853,402,695.57	551,687,497.30	3,032,125,057.93



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,774,679,500.00</b>	<b>3,520,397,319.82</b>	<b>254,282,180.18</b>	<b>93.3</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,774,679,500.00</b>	<b>3,520,397,319.82</b>	<b>254,282,180.18</b>	<b>93.3</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,585,373,300.00</b>	<b>3,351,369,946.82</b>	<b>234,003,353.18</b>	<b>93.5</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,664,547,500.00</b>	<b>2,478,102,466.91</b>	<b>186,445,033.09</b>	<b>93.0</b>
210101	Үндсэн цалин	1,803,999,100.00	1,445,411,429.96	358,587,670.04	80.1
210102	Нэмэгдэл	710,610,200.00	736,167,800.50	-25,557,600.50	103.6
210104	Урамшуулал	149,938,200.00	296,523,236.45	-46,585,036.45	197.8
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>333,068,500.00</b>	<b>289,379,021.28</b>	<b>43,689,478.72</b>	<b>86.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	226,486,600.00	192,013,098.08	34,473,501.92	84.8
210202	Тэтгэмжийн даатгал	26,645,500.00	25,350,501.23	1,294,998.77	95.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,322,700.00	12,672,925.79	649,774.21	95.1
210204	Ажилгүйдлийн даатгал	13,322,700.00	12,678,350.88	644,349.12	95.2
210205	Эрүүл мэндийн даатгал	53,291,000.00	46,664,145.30	6,626,854.70	87.6
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>307,415,700.00</b>	<b>307,326,896.88</b>	<b>88,803.12</b>	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,000,100.00	13,912,066.88	88,033.12	99.4
210302	Түлш, халаалт	264,915,600.00	264,915,248.00	352.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	28,500,000.00	28,499,582.00	418.00	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,500,000.00</b>	<b>7,491,200.00</b>	<b>8,800.00</b>	<b>99.9</b>
210604	Урсгал засвар	7,500,000.00	7,491,200.00	8,800.00	99.9
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>61,353,000.00</b>	<b>61,246,078.18</b>	<b>106,921.82</b>	<b>99.8</b>
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	37,600.00	-	37,600.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	61,315,400.00	61,246,078.18	69,321.82	99.9
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>211,488,600.00</b>	<b>207,824,283.57</b>	<b>3,664,316.43</b>	<b>98.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	184,259,000.00	186,356,891.57	-2,097,891.57	101.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,229,600.00	21,467,392.00	5,762,208.00	78.8
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>189,306,200.00</b>	<b>169,027,373.00</b>	<b>20,278,827.00</b>	<b>89.3</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>189,306,200.00</b>	<b>169,027,373.00</b>	<b>20,278,827.00</b>	<b>89.3</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	146,188,900.00	125,100,073.00	21,088,827.00	85.5
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	43,117,300.00	43,927,300.00	-810,000.00	101.9
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,774,679,500.00</b>	<b>3,537,645,950.00</b>	<b>237,033,550.00</b>	<b>93.7</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,206,983,900.00</b>	<b>3,206,983,900.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,206,983,900.00	3,206,983,900.00	-	100.0
310002	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>314,915,700.00</b>	<b>314,915,700.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
	Орон нутгийн төсвөөс	314,915,700.00	314,915,700.00	-	100.0

**Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	252,779,900.00	15,746,350.00	237,033,550.00	6.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,105,000.00	15,746,350.00	1,358,650.00	92.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,105,000.00	15,746,350.00	1,358,650.00	92.1
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	235,674,900.00		235,674,900.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	235,701,857.63	-235,701,857.63	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		252,852,884.69	-252,852,884.69	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>102</b>	<b>98</b>	<b>4</b>	<b>96.1</b>
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	85	84	1	98.8
620003	Үйлчлэх ажилтан	16	13	3	81.3
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>1414</b>	<b>1426</b>	<b>-12</b>	<b>100.8</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>1414</b>	<b>1426</b>	<b>-12</b>	<b>100.8</b>
630001	Төрийн өмчит ЕБС	1414	1426	-12	100.8

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон “Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургууль нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба бүтэц зохион байгуулалттай 98 орон тоотой, 1426 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх



тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” 25 дугаар тогтоолын хавсралт” Боловсролын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр журам батлах тухай” 39 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд Боловсролын ерөнхий газар болон аймгийн боловсролын газрын хамтарсан хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын шалгалт хийгдэж Нрдэм сургуульд 4,675.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 5,658.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, “УСНББОУС-1”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 138,875.7 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт А	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	235,701.9	252,852.9	17,151.0
Авлага	-	350.0	350.0
Бараа материал	150,320.8	224,104.5	73,783.7
Үндсэн хөрөнгө	3,079,852.1	3,302,643.8	222,791.7
Хуримтлагдсан элэгдэл	- 519,680.1	- 694,880.8	- 175,200.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,946,194.6</b>	<b>3,085,070.3</b>	<b>138,875.7</b>
Өр төлбөр	-	52,945.2	52,945.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,946,194.6	3,032,125.1	85,930.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,946,194.6</b>	<b>3,085,070.3</b>	<b>138,875.7</b>

*Эх сурвалж: Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө ,авлага, бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 235,701.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 252,852.9 мянган төгрөгийн өмнөх оноос 17,151.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд байгууллагаас авах авлага 350.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 128,446.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 46,941.8 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй шилжиж ирсэн 101,604.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж бараа материалын үлдэгдэл 73,783.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө тайлант онд Боловсролын ерөнхий газраас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 105,581.7 мянган төгрөг, худалдан авсан 117,210.0 мянган төгрөг, нийт 222,791.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд цахим ангийн тоног төхөөрөмжийн өглөг 52,945.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 85,930.4 мянган төгрөгөөр нэмэгдэж 3,032,125.1 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 85,930.4 мянган төгрөгөөр нэмэгдэж 3,032,125.1 мянган төгрөг болсон байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,549,574.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 349,748.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 657,409.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 34,835.8 мянган төгрөгөөр бууруулж баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 16 арга хэмжээг санхүүжүүлэх зардлын эх үүсвэрийг улсын төсвөөс 3,206,983.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 15,746.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 314,915.7 мянган төгрөгөөр тус тус бүрдүүлэхээс гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,206,983.9 мянган төгрөг, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогоос 15,746.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсвөөс цалин, нийгмийн даатгалын зардлуудад 2,767,481.5 мянган төгрөг, нормативт зардалд 203,601.1 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгийн зардалд 169,027.4 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардал 65,469.2 мянган төгрөг, нийт 3,205,579.2 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвөөс 314,915.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж байр ашиглалтын зардалд 307,326.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 7,491.2 мянган төгрөг, нийт 314,818.1 мянган төгрөгийг зарцуулж 97.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Улсын төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,520,397.4 мянган төгрөг буюу 93.3 хувь, орон нутгийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл 314,818.1 мянган төгрөг буюу 99.9 хувь байгаа нь улсын төсвийн зардлыг хэмнэн дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71601	Ерөнхий боловсролын сургалт	3,774,679.5	3,520,397.3	254,282.2	93.3
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,209,104.6	2,975,305.8	233,798.8	92.7
80802	Бусад урсгал шилжүүлэг	189,306.2	169,027.4	20,278.8	89.3
83112	Бараа үйлчилгээний бусад зардал	376,268.7	376,064.2	204.5	99.9

Эх сурвалж: 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Баян ташаагийн эх” аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Т.Хоролсүрэн, хоёр дахь шатны хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг “Баян ташаагийн эх” аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Ц.Загдсүм, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Төмөрхуяг нар зурж ажиллажээ.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг “АДБОУС 2320” дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийн зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг оны батлагдсан төсөв 2,339,984.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,399.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 16,379.9 мянган төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,400,303.5 мянган төгрөгийн 28 гүйлгээ, зарлагын 426,296.1 мянган төгрөгийн 30 гүйлгээг хуулийн хугацаанд



мэдээлсэн байна. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, хагас жилийн санхүүгийн тайлан 2 мэдээг тус тус хугацаа хоцроон мэдээлсэн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Худалдан авах ажиллагааны талаар

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөл, худалдан авах 205,682.1 мянган төгрөгийг тусгаж баталснаас, гүйцэтгэлээр 184,585.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үдийн цай хөтөлбөр хүнсний материал нээлттэй тендер шалгаруулах журмаар 125,100.1 мянган төгрөг, Хүүхдэд ээлтэй орчин төсөл хөтөлбөрийн хүрээнд 59,485.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авалтын аргаар цахим дэлгүүрээс, тоног төхөөрөмж 57,724.7 мянган төгрөг, хангамж бичиг хэргийн материал 128,446.4 мянган төгрөг нийт 185,171.1 мянган төгрөгийн бараа материал, тоног төхөөрөмжийг шууд худалдан авалтын аргаар худалдаж авсан байна.

Тус сургууль үдийн хоолны 125,100.1 мянган төгрөгийн материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг харьцууллын аргаар зохион байгуулахаар 2024 оны 2 дугаар сарын 01-ний худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д тендерийн бичиг баримтыг байршуулсан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг “Баян ташаагийн эх” аудит ХХК-ийн захирал Т.Хоролсүрэн гүйцэтгэж 3,022.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 128,628.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн. Аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг тус байгууллагаас 2024 оны 03 дугаар сарын 27-ны 27 тоот албан бичгээр ирүүлж бүрэн биелүүлж ажиллажээ.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3,022.8	1	3,022.8	100
Зөвлөмж	1	128,628.0	1	128,628.0	50.0
Нийт дүн	2	131,650.8	2	131,650.8	100

Эх сурвалж: төлбөрийг 2024 оны 03.27 –ны төлбөрийн баримт

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын урамшууллыг олгохдоо “Өөрчлөлтгүй” гэж дүгнэгдсэн боловч төлбөрийг акт тогтоосон байхад нягтлан бодогч үндсэн цалингийн 3 сартай тэнцэх хэмжээний урамшуулал олгох тушаал гарган олгосон байна. Иймд дараагийн аудитаар дээрх урамшууллыг хавтгайруулан олгосон эсэх асуудлыг авч үзэх шаардлагатай.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,544.0 мянган төгрөгийн 1 зөрчил<sup>1</sup> илэрсэнд албан шаардлага хүргүүлэв.

#### 5.1 Албан шаардлага

Боловсрол Шинжлэх ухааны яамны 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 2/2772 дугаар албан бичгийг үндэслэн аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” Б/42 дугаар тушаалаар төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх 1,544.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах мөн 16.5.5 - батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоох зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

### 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2024.07.09 өдрийн Б/42 тоот тушаалаар төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх хэмжээгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1., 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалттай нийцэхгүй байна	1	1,544.0			1	1,544.0		
	<b>1</b>	<b>1,544.0</b>			<b>1</b>	<b>1,544.0</b>		

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, хагас жилийн санхүүгийн тайлан 2 мэдээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1		1					
Дүн	1		1					

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар

146/11425044/АНА-2025/  
133/НА-СТА-ТЦЗ

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Эрдэм ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсролын ерөнхий газар, аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 2/2772 тоот албан бичгийг үндэслэн төсвийн шууд захирагчид нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 1,544,000 (Нэг сая таван зуун дөчин дөрвөн мянган) төгрөгийн балансын шагнал урамшууллыг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8. байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй;" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:


1. Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоож, зөрчлийг арилгасан талаарх нотлох баримтыг FAS системд оруулж, албан шаардлагын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 25-ний өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

6425040431


AUDIT 2025

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Эрдэм сургуулийн захирал Ц.Загдсүм, нягтлан бодогч Д.Төмөрхуяг нарт даалгав<sup>1</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>2</sup>**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ТАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

"БАЯН ТАШААГИЙН ЭХ"  
АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ  Т.ХОРОЛСҮРЭН



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум. Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хүүлиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 144/11425044/БНА-2025/  
434/НА-СТА/ТШЗ Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Эрдэм ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,400,303.5 мянган төгрөгийн 28 гүйлгээ, зарлагын 426,296.1 мянган төгрөгийн 30 гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, хагас жилийн санхүүгийн тайлан 2 мэдээг тус тус хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлага, орлогын мэдээллийг байршуулаагүй зөрчлийг арилган таслан зогсоож,

5125040195  
AUDIT 2025

зөрчлийг арилгасан талаарх нотлох баримтыг FAS системд оруулж, албан шаардлагын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Эрдэм сургуулийн захирал Ц.Загдсүм, нягтлан бодогч Д.Төмөрхуяг нарт даалгав<sup>2</sup>.

### АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

"БАЯН ТАШААГИЙН ЭХ"  
АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ  Т.ХОРОЛСҮРЭН

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно